



“Сиэл Монгол” тур операторын байгальд ээлтэй иргэдийн гарын авлага

Байгаль орчин бол бидний хамгийн үнэ цэнтэй баялаг юм. Хогоо байгаль орчинд бүү хаяцгаа. Та, таны эцэг эх, үр хүүхэд, өвөг дээдэс байгаль эхээ шүтэн, түүнээс хамааран нүүдэллэн аж төрж байгааг хэзээ ч мартаж болохгүй.

“Сиэл Монгол” нь жуулчдыг хүлээн авч орон нутгаар аялуулахдаа Монгол улсын үзэсгэлэнт газар, монгол хүний сэтгэл, нүүдэлчдийн соёл, зан заншил болон байгалийн гайхамшгийг тэдэнд харуулахыг зорьдог. Онгон дагшин байгаль мөн байгаль орчиндоо ээлтэйгээр зохицон амьдардаг нүүдэлчин ард түмний соёл, аж ахуйг танин мэдэх нь гадны иргэдийн хувьд монгол орныг зорин ирэх зухал хүчин зүйл нь болдог.

Бид жуулчдаас монгол орноор аялан өнгөрөхдөө байгаль орчиноо бохирдуулахгүй байхыг хүсдэг.

Тиймээс тэдэнд хэрэглэсэн хог хаягдалаа цуглуулж, байгальд хаяхгүй байхыг зөвлөдөг. Гэхдээ үүнийг хийхийн тулд та бүхний хамтын ажиллагаа, туслалцаа шаардлагатай болно.

Бүгдээрээ эх орныхоо байгаль дэлхийг хамтдаа хамгаалцгаая!

Хариуцлагатай аялал жуулчлал хийх бидний 10 зарчим:

Эдгээр зарчмыг дагаж мөрдөхөд та бүхний туслалцаа бидэнд хэрэгтэй, бид хамтдаа хүчтэй!

- Малчин айл өрхүүдийг хот суурин газар нүүлгэн шилжүүлэхгүйгээр тэднийг уламжлалт нүүдэлчин аж ахуйн хэв шинжийг үргэлжлүүлэн хадгалж үлдэхэд нь тус болох үүднээс нэмэлт санхүүгийн дэмжлэг үзүүлэх (айлаас айл аялал).
- Аялалын төлөвлөгөө зохиож түүнийгээ хэрэгжүүлэхдээ хүн болоод байгалийн үнэ цэнийг хүндэтгэх.
- Байгалийн цогцолборт болон дархан цаазат газарт гал түлж, хог болон тамхины ишээ хаяж, хоноглохгүй байх.
- Нүүдэлчин аж ахуйн өдөр тутмын амьдралтай холбоотой олон төрлийн үйл ажиллагаа жуулчдад санал болгох, тиймээс хэт олон хүнтэй аялал хийхээс зайлсхийх (ялангуяа айлаас айл аялалд)
- “Slow Travel” (Тайван аялал)- ыг дэмжих. Энэ нь дэлхийн үймээн шуугианаас холуур олон шинэ зүйлтэй учирч, өөр улс орны соёл, зан заншил, ард түмэнтэй танилцаж илүү танин мэдэхэд цаг гаргах.
- Нүүдэлчин айл өрхүүдийн амьдралд үүсэх сөрөг нөлөөллөлийг багасгах (айлаас айл аялалд). Малчин айл өрхүүдийг жуулчин хүлээн авах үедээ өдөр тутмын амьдрал болон дадал зуршилаа өөрчлөлгүй хэвээр нь хадгалахыг сануулдаг.
- Хамгийн ихдээ 8-10 хүнтэй группээр аялах. Энэ нь байгаль орчинд болон нүүдэлчин айл өрхүүдийн хэв маягт сөргөөр нөлөөлж болох жуулчдын нөлөөллийг багасгах мөн жинхэнэ монгол айлтай танилцаж хуучны зочиломтгой хэв шинжийг хадгалах зорилготой.
- Жуулчдыг олон хөлийн газраас хол онгон, дагшин зэрлэг байгалтай газар аваачих.
- Эдийн засгийн өнөөгийн ханштай уялдуулан хүмүүсд шударгаар ажлын хөлсийг олгох.
- Таны хүлээн авч үйлчилж буй аялал утга учиртай, сэтгэлд үлдэм, мартагдахааргүй байх хэрэгтэй.